

Natalie Silverstein  
Goldman Environmental Prize  
(415) 345-6330  
natalie@goldmanprize.org

Дашийн Гэрэт-Од  
Хэвлэл мэдээллийн зөвлөх  
9191-3943  
geegii\_od@yahoo.co.uk

**2007 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 22-НИЙ ӨДРИЙН  
ОРОН НУТГИЙН 12:01 ЦАГ ХҮРТЭЛ НИЙТЭД ХААЛЛТТАЙ**

**ЗУРГААН ХҮН ГОЛДМАНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ 125,000 АМ.ДОЛЛАРЫН  
ШАГНАЛААР ШАГНАГДАВ.**

*Shell Oil-ын хууль бусаар зөвшөөрүүлсэн газрын тосны дамжуулах хоолойг эсэргүүцсэний төлөө шоронд хоригдож байсан малчин, түүнчлэн Хойд Атлантаас загас барих эрхийг худалдан авч байхыг санаачилсан хувиараа аж ахуй эрхлэгч нар байгаль орчны салбар дахь хамгийн том шагналаар шагнагдсан зургаан хүний хоёр нь юм.*

**САН ФРАНЦИСКО, 2007 ОНЫ 4 САРЫН 22** - Өөрийнх нь газар нутаг дээгүүр Shell Oil-ын газрын тосны дамжуулах хоолойг байгуулахыг эсэргүүцсэний төлөө шоронд хоригдож байсан Ирландын фермер, түүнчлэн загас барих эрхийг худалдан авч байхыг санаачилсан Хойд Атлантын орнуудын засгийн газар, хувийн бизнесүүдтэй тохиролцсоны дүнд Хойд Атлантын зэрлэг салмон загасыг авран хамгаалсан Айландын хувиараа аж ахуй эрхлэгч нар энэ жилийн Голдманы байгаль орчны нэр хүндтэй шагналаар шагнагдсын дунд байна.

“Энэ жилийн шагналтнууд нь байгаль орчныг хамгаалахад гарч байгаа хамгийн хүндрэлтэй асуудлуудын заримыг нь амжилттайгаар шийдвэрлэж чадсан хүмүүс юм” гэж Голдманы шагналыг бий болгогч ноён Ричард Н. Голдман шагнагсдыг үнэлэн цааш нь хэлэхдээ “Энэ хүмүүс хувийн аж амьдралаа өндөр эрсдэлд оруулан байж энэ үйл хэрэгт хүчин зүтгэж байгаа нь жирийн хүмүүс өөрчлөлт хийхийн төлөө ямар их зүйл хийж чаддаг юм бэ гэдэг дээр биднийг бодлоо өөрчлөхөд хүргэж байна” гэв.

Арван найм дахь жилдээ олгогдож байгаа энэхүү 125,000 ам.долларын шагналаар нэг жилд зургаан хүнийг шагнадаг бөгөөд байгаль орчны салбарт олгогддог дэлхийн хамгийн том шагнал юм. Шагналтнууд 2007 оны 4 дүгээр сарын 22-ны оройн 5 цагт Сан Франциско хотын Дуурийн театрт болох зөвхөн урилгаар орох ёслолын ажиллагааны үеэр шагналаа гардан авна.

**Энэ жилийн шагналтнууд:**

**Ази: Ц. Мөнхбаяр, 40 настай, Монгол Улс:** Мөнхбаяр нь ус ховор Монголын тал дээгүүр урсах голын дагуух байгаль орчныг сүйтгэж буй уул уурхай – алт олборлолтын үйл ажиллагааг зогсооход төрийн болон олон нийтийн үүсгэл санаачилгын

байгууллагуудтай хамтран амжилттай ажилласан юм. Тэрээр одоо иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх, улс төрийн идэвхитэй үйл ажиллагаа явуулах замаар Монголд улам ховордож буй үнэт эрдэнэ - усыг цаашдын хариуцлагагүй уул уурхайн үйл ажиллагаанаас үр бүтээлтэйгээр хамгаалахад хүчин зүтгэж байна.

**Хойд Америк: София Рибляскас, 47 настай, Канад Улс:** Тэрээр Поплар голын уугуул иргэдийн эрх ашгийн өмнөөс тэмцэж Манитоба-ийн ойг түр зуурын хамгаалалтад оруулж чадсан бөгөөд одоо ой модны үйлдвэрлэл эрхлэх, усан цахилгаан станц байгуулах ажиллагааг зогсоон энэ ойн бүсийг байнгын хамгаалалтад оруулахын тулд төрийн болон олон улсын байгууллагуудтай ажиллаж байна.

**Африк: Хаммерсколд Симвинга, 45 настай, Замби Улс:** Замби улсын Хойд Лингуа Хөндийд хууль бусаар ан агнах явдал газар авч байгаагийн уршгаар зэрлэг зааны тоо толгойг цөөрч тосгоны иргэд ядуурлын дээд зэрэгт хүрээд байсан нөхцөлд Симвинга нийтийн тогтвортой хөгжлийн хөтөлбөр санаачилан хэрэгжүүлж зэрлэг ан амьтдыг хууль бусаар агнах явдлыг амжилттайгаар зогсоон ядууралд автсан газар нутгийг сэргээж чадсан юм.

**Өмнөд ба Төв Америк: Жулио Кусуричи Паласиос, 36 настай, Перу Улс:** Кусуричи нь борооны ойн эмзэг эко бүтцийг хамгаалах, түүнчлэн мод үйлдвэрлэл, уул уурхайн үйл ажиллагаанаас байгальд учруулж буй хор хохирлоос дайжин сайн дураараа алс цөглөг газар руу нүүн суурьшсан нутгийн уугуул иргэдийг эрхийг хамгаалж алс зайдуу Перугийн Амазонд үндэсний нөөцийн газрыг бий болгожээ.

**Европ: Вилли Кордаф, 53 настай, Ирланд Улс:** Кордаф нь нутгийн иргэд, газрын эзэдтэй хамтран Shell Oil-ийн эсрэг тэмцэн Росс Портын жижиг мал аж ахуйн газар дээгүүр хууль бус зөвшөөрөлтэйгээр газрын тосны дамжуулах хоолой барих гэж байсныг зогсоож чадсан байна.

**Айланд болон Айландын Газар Нутаг: Ори Фигузин, 64 настай, Айланд Улс:** Чадварлаг бизнесмэн Фигузин Хойд Атлантын бараг устах шахсан зэрлэг салмон загасыг хамгаалахын төлөө эргэлт буцалтгүйгээр зүтгэсний дүнд загас барих олон улсын эрх худалдан авч байх санаачилгыг гарган холбогдох улсуудын төрийн болон олон улсын байгууллагуудаар зөвшөөрүүлж чаджээ. Ийнхүү энэ бүс нутагт салмоньг устахад хүргэж байсан загасны үйлдвэрүүдийг хаахад тэр өөрийн хувь нэмрээ оруулж чадсан юм.

### **Голдманы Байгаль Орчны Шагналын Тухай**

Голдманы Байгаль Орчны Шагналыг Сан Франциско хотын олон нийт, нийгмийн нэр хүндтэй зүтгэлтэн Ричард Н. Голдман ба түүний эхнэр агсан Рода Н. Голдман нар 1990 онд анх санаачилсан юм. Энэ шагналаар одоогийн байдлаар 70 орны 119 хүн шагнагдаад байна.

Шагнагдагсдыг олон улсын хэмжээнд байгаль орчны салбарын байгууллага, хүмүүсийн сүлжээнээс нууцаар нэр дэвшүүлж олон улсын шүүгчдийн санал хураалтаар шүүн шалгаруулдаг.

Голдманы байгаль орчноор шагнагдагсад нь байгаль орчны салбарт дэлхийн хэмжээнд тулгарч байсан хамгийн хурц асуудлуудын төвд явж байдаг хүмүүс юм. Тухайлан, Энэтхэгийн Хайрын Канал ба Хопалд болсон байгалийн гамшгаар хохирогчдын эрх ашгийг хамгаалах; туна загасыг хамгаалах хөдөлгөөнийг манлайлах; Арктикийн үндэсний тусгай хамгаалалттай газарт газрын тосны цооног өрөмдөхийн эсрэг тэмцэх, АНУ-ын цагаан идээний бүтэгдхүүнд гBGH гормон хэрэглэхэд Монсанто-ийн оруулсан хувь нэмрийг илчлэх зэрэг үйл ажиллагаануудыг энд дурдаж болно.

Голдманы байгаль орчны шагналыг авсан хүмүүсээс найм нь өөрийн улсын төрийн өндөр албан тушаалд сонгогдох буюу томилогдож байсан бөгөөд тэдний нэлээд нь байгаль орчны сайдаар ажиллаж байна. Мөн 1991 онд Африк тивээс шалгарч Голдманы байгаль орчны шагналын эзэн болсон Вангари Маатай 2004 онд Нобелийн шагнал хүртсэн юм.

###

**СОНИНГИЙН ЭРХЛЭГЧ НАРЫН АНХААРАЛД:** Шагналтнуудын товч түүх, зургийг [http://www.goldmanprize.org/2007media\\_intl](http://www.goldmanprize.org/2007media_intl) гэсэн вебсайтаас татаж болно. Түүнчлэн телевизээр гаргах сайн чанарын видео дүрс болон дуу бичлэгийг шагналтнуудын харьяалах улсаас авч болно. Голдманы байгаль орчны шагнал болон шагналтнуудын тухай нэмэлт мэдээллийг [www.goldmanprize.org](http://www.goldmanprize.org) гэсэн вебсайтаас авна уу.